

**Өлгийсумын ЗДТГ-ын 05-р сарын 04-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2018.05.10

- Аймгийн прокурорын газраас ирүүлсэн журмын хэрэгжилтийг хангуулах тухай зөвлөмжийн дагуу захиргааны зөрчлийн улмаас хураагдсан эд хөрөнгийг орлого болгож, үнэ тогтоож худалдан борлуулах, устгах ажлын комиссыг шинэчлэн байгуулж, хувийг холбогдох газарт хүргүүлэв.
- “Соёлтой хот ” сарын аяны хүрээнд айл, өрх иргэн ААН байгууллагуудад цэвэрлэгээ хийсэн ажлын талаарх тайланг фото зургаар баримтжуулан авч, цаашид байнгын хяналт тавьж ажиллаж байна.
- 5 дугаар сарын 5-ны өдөр болсон хүчтэй салхи шуурганы улмаас эд хохирол учирсан айл өрхүүдийн судалгааг Багийн Засаг дарга нараар гаргуулж хохирлын хэмжээг үнэн бодит байдлаар тогтоох ажил хийгдэж байна.
- Хотын төвийн хатуу хучилттай авто замд хийгдэх нөхөөс засварын хэмжилт, тооцоог хийж аймгийн ЗДТГ-д хүргүүлэв.
- “Соёлтой хот” аяны хүрээнд хотын төв хэсгийн авто замд хийгдэх тэмдэг, тэмдэглэгээний ажлын хэмжээг гаргаж холбогдох газарт танилцуулав.
- Өлгий сумын орчин суугчдын нийтлэг журмын төслийг боловсруулж байгаа.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах газруудыг хянан үзэж газрын даамлуудын хамт бэлтгэв.
- “Соёлтой хот” аяны хүрээнд албан хаагч нар байгууллагын гаднах орчин талбайг цэвэрлэв.
- БИНХурлаас гарсан 2019 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулгыг нэгтгэж эрэмбэлэх ажлыг хийж эхлэв.
- Өлгий сумын хэмжээнд байгаа мал бүхий иргэдийн судалгааг гаргаж онцгой байдлын газарт санал хүргүүлж 1800ш боодол өвс шийдвэрлүүлж баг тус бүрт хувиарлаж БЗДарга нараар тарах ажлыг зохион байгуулав.
- “Жишиг гудамж” хэрэгжүүлэхээр багуудаас сонгож авсан гудамжийг газар дээр нь үзэж цаашид ямар ажил зохион байгуулах арга хэмжээ авах талаар ажлын хэсэг байгуулах ажлын бэлтгэлийг хангаж ажиллаж байна.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 5н хог ачиж хогийн цэгт хүргэв.
- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, урсгал засваруудыг хийж байна
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж байна
- Ногоон бүсийн модон хашааны болон цэцгийн мандлуудын нурж унасан хэсгийг засварлаж шороог янзалж цэцэг тарихад бэлдэж байна.
- Хогийн цэгийг шинэ газарт хог асгах нөхцөлөөр хангаж түрж тэгшлэх ажил хийж байна.
- Ногоон бүс болон цэнгэлдэх хүрээлэнд усалгааны ажилд зориулан худаг ухаж ашиглалтанд өгсөн усалгааг эхэлж хийж байна
- Төв цэнгэлдэх хүрээлэн болон ногоон бүсүүдийг усалгааны машинаар талбайн усалгаа хийж байна.
- 10 дугаар багийн усалгааны моторыг суурилуулж тогны асуудлыг шийдвэрлэсэн.
- Бүх нийтээр мод тарих өдрийн бэлтгэл ажил хийж байна.
- Зоонозын байгууллагын сургалт явагдах болсонтой холбоотой Аймгаас өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу Цагааннуурт 3ш жорлон байрлуулан, бш хогийн сав тавих ажлыг хийв.

Өлгий сумын ЗДТГ